

23

**“МОНГОЛ НЭХМЭЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ТОГТООЛ**

2017.04.28

Дугаар 01

Улаанбаатар хот


Компанийн жилийн үйл ажиллагааны болон
санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн
удирдах зөвлөлийн дүгнэлт, ТУЗ-ийн
ажлын тайлангийн тухай.

“Монгол нэхмэл” хувьцаат компанийн 2016 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлөөс оруулсан дүгнэлтийг хэлэлцээд, тус компани нь 2016 онд үйл ажиллагаа хэвийн явагдсан боловч үйл ажиллагааны зардалаа нөхөөд алдагдалтай ажилласаныг тэмдэглэж байна.

Компаний тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 9 дахь заалт, 46 дугаар зүйлийн 6 дахь заалт, хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн хувьцаа эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ НЬ:**

1. “Монгол нэхмэл” Хувьцаат компанийн 2016 оны жилийн үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайланд өгсөн ТУЗ-ийн дүгнэлтийг баталсугай.
2. Компанийн санхүүгийн үйл ажиллагааны тайлан, ТУЗ-ийн шийдвэрийг үндэслэн ногдол ашиг тараахгүй болохыг тэмдэглэсүгэй.
3. Компанийн Төлөлөн удирдах зөвлөлийн 2016 онд хийсэн ажлыг хангалттай гэж тогтоосугай.

ХУРЛЫН ДАРГА:



Р.ЭНХТАЙВАН

**“МОНГОЛ НЭХМЭЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ТОГТООЛ**

2017.04.28

Дугаар 02

Улаанбаатар хот

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
Ердийн болон хараат бус гишүүдийг
сонгох тухай.

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт, хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд

а. Ердийн гишүүд


1. Р.Энхтайван
2. Р.Энхболд
3. С.Мандухай
4. Р.Байгалмаа
5. Т.Өнөрсайхан
6. Э.Энхжин

б. Хараат бус гишүүд

1. Н.Энхбаатар
2. Ж.Оюунчимэг
3. Н.Энэбиш нарын гишүүдийг

2017 оны 04 дүгээр сарын 28-ны өдрөөс эхлэн 2022 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хүртэл 5 жилийн хугацаагаар **сонгосугай.**

ХУРЛЫН ДАРГА:



Р.ЭНХТАЙВАН